

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/68/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг)
2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 7052-2734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас: 7052-3020 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn
Аудитор: Б.Байгал
Утас: 99359854 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
НХМ	Нэг хэвийн маягт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12
3.1	(Аудитын чиглэл)	
3.1.1	Илрүүлэлт:	
3.1.2	Эрсдэл:.....	
3.1.3	Өгсөн зөвлөмж:.....	
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	
3.2	(Аудитын чиглэл)	
3.2.1	Илрүүлэлт:	
3.2.2	Эрсдэл:.....	
3.2.3	Өгсөн зөвлөмж:.....	
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Н.ОЮУНБУД ТАНАА
2019.02.15 № 46/73	
Танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Оюун буд-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.17-ноос 2019.01.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын гэрээт “Мөнгө нөөц баялаг Аудит” ХХК-н хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Мөнгө нөөц баялаг Аудит” ХХК-д 2019.01.24-ны өдрийн 19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь Суралцагч нэг бүрийг мэдлэгтэй, мэдрэмжтэй, ёс суртахуунлаг, сайхан сэтгэлтэй, эрүүл чийрэг бие бялдартай, хүнлэг энэрэнгүй болгож төлөвшүүлэхийг зорино. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагааг Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын нэг буюу хэд хэдэн төвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх,

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

БСШУС сайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаал "Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив"

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "AGOLOUS" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 2 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт орлогын 1* хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төлөвлөлтийн шатанд нийт орлогыг суурь болгож авсныг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2018 оны *Нийт орлого* 10,722.43 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 10,722.43 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь орлогын 1 хувиас бага эрсдэл нь санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа,

зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна санхүүгийн тайлангийн дансны уялдааг шалгаж зөрүүтэй асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	0.00	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

“Тайлант үеийн санхүүгийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэнтэй холбогдон санхүүгийн программ шинэчлэх, дахин үнэлгээг санхүүгийн тайланд тусгахдаа зөрүүтэй илэрхийлэх зэрэг бэрхшээл гарсан болно.” Түүнчлэн үнэлгээ хийх хугацаа, санхүүгийн тайлан гаргах хугацаа давхцаж байгаагаас аудитын байгууллагат зөрүүтэй тайлан ирүүлэх, аудит хийх хугацаанд нөлөөлөх зэрэг асуудал гарлаа. Нягтлан бодогчдын ирүүлсэн санхүүгийн тайланг аудитаар хөрвүүлэн авсан боловч хөрөнгийн элэгдлийн дүн зөрүүтэй, тайлант оны үр дүн зөрүүтэй байгааг буцааж засуулж авсны дараа аудитыг хийж гүйцэтгэсэн.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар орон тоо цалин хөлсийг шалгах нь зүйтэй гэж үзсэн болно.

Тус сургуулийн жилийн төсвийг батлахдаа ашиглалтад ороогүй бага сургуулийн төсөвтэй хамт батлуулж дахин хуваарилалт хийж байгааг цаашид анхаарах. Түүнчлэн тайлант онд батлуулан авсан ашиглалтад ороогүй бага сургуулийн төсвийг хэрхэн зарцуулсан талаарх нэгтгэсэн дүнг Төвлөрүүлэн захирагчийн нэгдсэн санхүүгийн тайлангийн аудитад тусгах шаардлагатай.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 11 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,028,740,7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлд, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,025,134,3 мянган төгрөг буюу 99,6 хувьтай байгаа нь Сургуулийн төсвийг 2018 оны төсөв 3,606,4 мянган төгрөгөөр хэмнэгдсэн үүнээс цалин хөлсний нэмэгдэлтэй уялдан НДШ-ийн зардал хэмнэгдсэн байна. Тайлант онд төлөвлөсөн үйл ажиллагааны орлого байхгүй байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9-д “нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг хэлнэ гэж тодорхойлсон бөгөөд тус хуулийн 5.1-д заасан зарчим, УСНББОУС-ыг баримтлан НББ-ийн бодлогын баримт бичгийг улам боловсронгуй болгож, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхой

тусгаж тогтвортой мөрдөх, бодлогын баримт бичигтэй уялдуулан үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртгийг дахин шалгах нь зүйтэй.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Удирдлагын дээд болон дотоод хяналт

Илрүүлэлт

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд тухайн байгууллагын тайлант онд дэвшүүлсэн зорилго зорилт, болон үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэл авах боломж хангалтгүй байна. Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний үүргийн биелэлтийн тайлан, тухайн байгууллагын үйл ажиллагааны тайлангуудад төсөв санхүүгийн үр дүн, гүйцэтгэлийн тоо мэдээлэл, тайлант онд хийгдсэн их болон урсгал засвар, худалдан авсан тоног төхөөрөмж түүний ашиглалт, ач холбогдлын талаар тодорхой тусгаагүй байна Энэ нь Төсвийн тухай хууль 40.2.Энэ хуулийн 40.1-д заасан үр дүнгийн гэрээнд байгууллагын төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн төсөв, хүрэх үр дүн, түүнийг дүгнэх талаар тусгасан заалтыг тус тус зөрчсөн байна.

Эрсдэл

Тухайн байгууллагын тайлант оны болон үйл ажиллагааны талаар шуурхай мэдээлэл авах боломж алдагдана.

Зөвлөмж

Байгууллагын үйл ажиллагааны тайлан, үр дүнгийн гэрээний үүргийн биелэлтийн тайланд төсөв санхүү үйл ажиллагааны өөрчлөлт шинэчлэлттэй холбоотой мэдээлэл оруулах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн ийн Захирал Н.Оюун-буд

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.2 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Илрүүлэлт

Төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийхдээ зарим ажил гүйлгээний анхан шатны баримтад худалдан авалтыг баталгаажуулсан Е баримт хавсаргаагүй байна. Мөн Төсвийн зарцуулалтыг шилжүүлэхдээ зарим ажил гүйлгээнд Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8-д заасан нотлох баримтыг бүрдүүлээгүй байна. Энэ нь НББ тухай хуулийн 13 дүгээр зүйл, Засгийн газрын 24 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2017.12.05 ны 347 тоот тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн ААН байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврыг /НХМ-ТМ-5/ тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Е баримтыг худалдан авалт хийсэн ажил гүйлгээ бүрд анхан шатны нотлох баримтаар авч зарцуулалт бүрийн нотлох баримтын бүрдүүлэлтийг сайжруулах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн ийн Захирал Н.Оюун буд нягтлан бодогч Э.Зол заяа

Эрсдэл

1. Бүртгэлээр тавих хяналт алдагдана.
2. Татварын орлого бүрдүүлэлт, тайлагнал дутуу илэрхийлэх боломж бүрдэнэ.

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.3 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

Илрүүлэлт

Тайлант онд тус байгууллага Сургуулийн захирлын 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/02 дугаар тушаалаар сургуулийн 2018 онд батлагдсан ажлын байрны тоог тогтоосон Нийт 64 ажилтан ажиллаж байгаагаас сургуульд 3, дотуур байранд 3 нийт 6 жижүүр ажиллаж байна. Энэ нь БСШУС Сайд, Сангийн сайдын хамтарсан А/024/11 тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив” орон тооны жишигтэй нийцэхгүй байна.

Зөвлөмж

Захиргааны ажилчдын орон тоог батлагдсан журамд нийцүүлэн оновчтой тогтоож мөрдөх

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн ийн Захирал Н.Оюун буд нягтлан бодогч Э.Зол заяа

Төсвийн захирагчийн хариу

Эрсдэл

1. Цалингийн зардал илүү зарцуулагдах эрсдэлтэй.

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.4 орлого зардлын уялдаа

Илрүүлэлт

Тайлант оны урсгал санхүүжилтээс 99,6 мянган төгрөгийн үр, 300,0 мянган төгрөгийн цалин хөлсний зардал гарсан байна. Гарсан зардлаар сургалтын хэрэгцээнд ашиглахаар авсан хүлэмж, гадна талбайд хүнсний ногоо тарьж ургуулсан боловч ургасан ногоог хураан авч бүртгээгүй, бодитоор ашиглаагүй орхигдуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хууль 6.3.4.төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байна гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

1. Үргүй зардал гарах эрсдэлтэй

Зөвлөмж

Төсвийн хөрөнгөөр сургалтын хэрэгцээнд ашиглахаар авсан хүлэмж, гадна талбайд тарьж ургуулсан ногоог хураан авч бүртгэн дотуур байрны хэрэгцээнд зарцуулж байх

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн ийн Захирал Н.Оюун буд нягтлан бодогч Э.Зол заяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25- ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ч.АРИУНАА	Огноо:
АУДИТЫН МЕНЕЖЕР	Ц.ЛҮНДЭГМАА	Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР	Б.БАЙГАЛ	Огноо:
---------	----------	--------

3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	134,155,416.68	162,891,737.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	9,504,290.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	9,504,290.00
3121	Төгрөг	00.00	9,504,290.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	9,504,290.00
33	АВЛАГА	00.00	46580,00
335	Бусад авлага	00.00	46580,00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	46580,00
35	БАРАА МАТЕРИАЛ	134,155,416.68	153,340,867.87
351	Түүхий эд материал	84,784,229.82	96,873,398.61
35110	Тусгай зориулалттай материал	84,784,229.82	96,818,778.61
35130	Эм боох материал	00.00	54,620.00
354	Хангамжийн материал	49,371,186.86	56,467,469.26
35410	Бичиг хэргийн материал	1,403,442.00	2,103,242.00
35420	Аж ахуйн материал	46,053,282.06	54,030,511.06
35460	Хүнсний материал	1,914,462.80	333,716.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,044,187,483.40	1,808,191,678.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,044,187,483.40	1,808,191,678.24
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	2,044,101,546.01	1,455,500,115.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,302,967,222.00	1,314,960,770.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-415,153,949.87	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	210,416,570.70	222,128,470.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-133,573,077.79	-163,935,224.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	113,044,787.01	118,726,787.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-57,402,332.96	-66,889,501.69
39209	Зам, гүүрийн байгууламж	00.00	4,223,740.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-580,500.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	35,636,531.77	40,596,651.77
39215	Хуримтлагдсан элэгдэл	-28,925,727.04	-32,108,371.18
39217	Ном	17,091,522.19	18,377,294.20
393	Биет бус хөрөнгө	85,937.39	352,691,562.37
39301	Програм хангамж	1,599,500.00	1,599,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,513,562.61	-1,547,937.63
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	352,640,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,178,342,900.08	1,971,083,416.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,161,258.00	23,866.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,161,258.00	23,866.00
413	Өглөг	2,161,258.00	23,866.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,176,181,642.08	1,971,059,550.11
51	Засгийн газрын хувь оролцоо	2,176,181,642.08	1,971,059,550.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	920,349,524.54	1,272,989,524.54
51101	Өмч: - төрийн	920,349,524.54	1,272,989,524.54
512	Хуримтлагдсан үр дүн	845,591,913.60	178,652,603.90
51210	Өмнөх үеийн үр дүн	845,591,913.60	845,591,913.60
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-666,939,309.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	410,240,203.94	519,417,421.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,178,342,900.08	1,971,083,416.11

3.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	492,561,646.00	1,072,242,645.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,977,326.00	32,450,615.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,977,326.00	32,450,615.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,977,326.00	32,450,615.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	13,880,867.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	731,446.00	218,790.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,245,880.00	18,350,958.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,584,320.00	11,051,330.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	1,028,740,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,924,820.00	11,051,330.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,199,900.00	11,051,330.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	724,920.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	486,659,500.00	00.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	486,659,500.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	512,471,116.75	1,026,627,428.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	512,471,116.75	1,026,627,428.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	494,285,116.75	956,675,465.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,985,443.00	591,255,983.43
210101	Үндсэн цалин	201,469,908.00	533,073,304.43
210102	Нэмэгдэл	105,215,535.00	44,047,000.00
210104	Урамшуулал	20,300,000.00	14,135,649.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,968,221.00	70,054,752.75
210201	Тэтгэврийн даатгал	23,653,085.00	46,977,527.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,462,967.00	4,875,744.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,078,809.00	5,626,368.89
210204	Ажилгүйдлийн даатгал	615,742.00	1,148,428.36
210205	Эрүүл мэндийн даатгал	6,157,618.00	11,426,683.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,527,443.00	148,745,065.00
210301	Гэрэл, цахилгаан	5,236,420.00	9,529,011.00
210302	Түлш, халаалт	50,791,023.00	125,601,454.00
210303	Цэвэр, бохир ус	6,500,000.00	13,614,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,478,998.00	30,816,339.21
210401	Бичиг хэрэг	684,879.00	1,954,290.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	893,869.00	2,221,849.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	132,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,168,250.00	24,880,848.21
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,299,352.00
2105	Нормативт зардал	9,811,803.00	25,110,194.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	129,050.00	91,180.00
210502	Хоол, хүнс	9,682,753.00	25,015,054.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	3,960.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	2,770,324.00
210604	Урсгал засвар	00.00	2,770,324.00
2107	Томиллолт, зочны зардал	229,100.00	673,900.00
210702	Дотоод албан томиллолт	229,100.00	673,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	622,700.00	2,105,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	622,700.00	2,105,300.00

Сайншанд сумын ЕБ-ын 3 дугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,661,408.75	85,143,636.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	851,710.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	252,000.00	3,576,706.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,409,408.75	80,715,220.75
69,951,962.82	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,186,000.00	69,905,382.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,186,000.00	65,924,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,186,000.00	33,582,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	19,468,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,872,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,606,382.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,606,382.82
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	375,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	375,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-19,909,470.75	45,661,796.44
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,210.83	712,601,106.14
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,210.83	1,667,727.99
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	710,933,378.15
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-11,210.83	-712,601,106.14
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-19,920,681.58	-666,939,309.70

3.3 Аудит хийсэн мөнгө гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	934,872,206.00	1,053,891,687.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,778,600.00	14,099,657.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,778,600.00	14,099,657.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,778,600.00	14,099,657.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	13,880,867.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,778,600.00	218,790.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	933,093,606.00	1,039,792,030.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	1,028,740,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,894,406.00	11,051,330.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,169,220.00	11,051,330.00
1330	Төсвийн захирагчдаас	914,199,200.00	00.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	914,199,200.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	922,703,366.00	958,562,020.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	922,703,366.00	958,562,020.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	789,934,052.00	888,765,757.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549,636,100.00	591,246,737.43
210101	Үндсэн цалин	333,325,000.00	402,663,004.43
210102	Нэмэгдэл	182,711,100.00	155,397,382.57
210104	Урамшуулал	33,600,000.00	33,186,350.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,717,000.00	72,186,010.75
210201	Тэтгэврийн даатгал	38,638,200.00	66,715,171.75
210202	Тэтгэмжийн даатгал	4,415,700.00	1,299,352.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,519,700.00	1,162,526.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,104,000.00	273,542.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,039,400.00	2,735,419.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,844,457.00	148,745,065.00
210301	Гэрэл, цахилгаан	10,397,795.00	9,529,011.00
210302	Түлш, халаалт	105,450,600.00	125,601,454.00

Сайншанд сумын ЕБ-ын 3 дугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	11,996,062.00	13,614,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,828,694.00	19,360,015.00
210401	Бичиг хэрэг	950,000.00	1,106,470.00
210402	Тээвэр, шатахуун	1,420,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,700,000.00	1,981,075.00
210404	Ном, хэвлэл	276,800.00	9,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	282,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,199,894.00	15,803,470.00
2105	Нормативт зардал	22,791,735.00	27,048,818.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	359,750.00	359,800.00
210502	Хоол, хүнс	20,867,625.00	23,590,008.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,564,360.00	3,099,010.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,799,726.00	11,571,234.00
210602	Тавилга	96,900.00	00.00
210604	Урсгал засвар	3,702,826.00	11,571,234.00
2107	Томилолт, зочны зардал	665,460.00	673,900.00
210702	Дотоод албан томилолт	665,460.00	673,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,448,900.00	2,299,561.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,448,900.00	2,299,561.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,201,980.00	15,634,416.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	750,000.00	3,638,770.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,451,980.00	11,995,646.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	132,769,314.00	69,796,262.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	130,377,600.00	65,768,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,208,400.00	33,427,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,905,600.00	19,468,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54,603,600.00	12,872,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,660,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,391,714.00	3,652,962.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,391,714.00	3,652,962.82
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	375,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	375,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,168,840.00	95,329,667.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,133,200.00	85,825,377.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,133,200.00	85,825,377.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,133,200.00	85,825,377.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,133,200.00	85,825,377.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-12,133,200.00	-85,825,377.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	35,640.00	9,504,290.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	9,504,290.00

3.5 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	920,349,524.54	410,240,203.94	818,138,221.93	00.00	2,148,727,950.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	920,349,524.54	410,240,203.94	818,138,221.93	00.00	2,148,727,950.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-19,920,681.58	00.00	-19,920,681.58
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	920,349,524.54	410,240,203.94	845,591,913.60	00.00	2,176,181,642.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	920,349,524.54	410,240,203.94	845,591,913.60	00.00	2,176,181,642.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	109,177,217.73	00.00	00.00	109,177,217.73
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	352,640,000.00	00.00	-666,939,309.70	00.00	-314,299,309.70
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,272,989,524.54	519,417,421.67	178,652,603.90	00.00	1,971,059,550.11

Сайншанд сумын ЕБ-ын 3 дугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,028,740,700.00	1,025,134,317.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,028,740,700.00	1,025,134,317.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	961,960,000.00	959,366,017.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	591,647,300.00	591,246,737.43
210101	Үндсэн цалин	347,159,000.00	402,663,004.43
210102	Нэмэгдэл	184,467,100.00	155,397,382.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	60,021,200.00	33,186,350.43
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,293,600.00	72,150,010.75
210201	Тэтгэврийн даатгал	50,427,600.00	66,679,171.75
210202	Тэтгэмжийн даатгал	5,966,500.00	1,299,352.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,773,200.00	1,162,526.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,193,300.00	273,542.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,933,000.00	2,735,419.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,745,100.00	148,745,065.00
210301	Гэрэл, цахилгаан	17,668,800.00	9,529,011.00
210302	Түлш, халаалт	111,041,100.00	125,601,454.00
210303	Цэвэр, бохир ус	20,035,200.00	13,614,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,398,700.00	16,352,815.00
210401	Бичиг хэрэг	1,100,000.00	1,096,770.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,150,000.00	1,981,075.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,540.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,188,700.00	12,314,430.00
2105	Нормативт зардал	22,298,100.00	22,296,498.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	360,000.00	359,800.00
210502	Хоол, хүнс	18,838,100.00	18,837,688.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,100,000.00	3,099,010.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,626,900.00	82,626,211.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,622,000.00	3,622,000.00
210604	Урсгал засвар	79,004,900.00	79,004,211.00
2107	Томилолт, зочны зардал	673,900.00	673,900.00
210702	Дотоод албан томилолт	673,900.00	673,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00	1,999,561.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	1,999,561.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23276400.00	23275219.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,576,400.00	1,575,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,700,000.00	21,699,489.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66780700.00	65768300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,780,700.00	65,768,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,739,500.00	33,427,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,468,800.00	19,468,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,872,400.00	12,872,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,028,740,700.00	1,028,740,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,028,740,700.00	1,028,740,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,028,740,700.00	1,028,740,700.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО		64
620001	Удирдах ажилтан		1
620002	Гүйцэтгэх ажилтан		45
620003	Үйлчилгээний ажилтан		18

Сайншанд сумын ЕБ-ын 3 дугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

НТ-2

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		15,225,117.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		15,225,117.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		15,225,117.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		36,000.00
210201	Тэтгэврийн даатгал		36,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		6,081,600.00
210401	Бичиг хэрэг		86,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,995,000.00
2105	Нормативт зардал		4,752,320.00
210502	Хоол, хүнс		4,752,320.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,502,000.00
210604	Урсгал засвар		1,502,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2553197.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,063,040.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		490,157.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	11051330.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		11,051,330.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		11,051,330.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		